



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2023. 06. 28 № ЗГ-1/107  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Хавсралт хуудастай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023.06.27 № ХТТ/1544  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт <sup>БХ</sup> хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА


Д.АМАРБАЯСГАЛАН

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 27 дугаар тэмдэглэлд:

“XVI.ХЭЛЭЛЦСЭН нь: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn


2023.06.26 № 01/4777

танай 2023.06.21 -ны № 14/3920 -т

### ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД С.ЧИНЗОРИГ ТАНАА

Танаас ирүүлсэн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761001419



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023. 06. 22 № 7/3510

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
С.ЧИНЗОРИГ ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

151603179

А3 Файл.2023



## НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Эрүүл монгол хүнийг төлөвшүүлэхэд нөлөөлж байгаа эдийн засаг, нийгэм, даяаршил, мэдээлэл, технологийн хөгжил, хотжилт, хэт төвлөрөл, орчны бохирдол, хүмүүсийн амьдралын хэв маяг, оюун санаа, үзэл бодолд гарч байгаа өөрчлөлттэй уялдуулан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжлийн бодлогод нийцүүлэн тодорхойлох, хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааны зохицуулалтыг шинэчлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл болон практик шаардлага байна:

### 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт иргэн “амьд явах эрхтэй”, 2 дахь хэсэгт “эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, 6 дахь хэсэгт “эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн тус тус заасан.

Эрүүл мэндийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ гэсэн 2 төрөлтэй болохыг, хүн амын эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхээр тодорхойлсон.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.1.1-д “Нийгмийн эрүүл мэндийн салбарын хөгжлийг дэмжиж, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлыг бүх шатны боловсролын байгууллага, хэвлэл мэдээллээр дамжуулан хэрэгжүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “... нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ”, “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ” гэж тодорхойлсон.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх “I үе шат буюу 2021-2030 онд эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн хүрээнд “иргэн, гэр бүл, ажил олгогчийн оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо бэхэжсэн байна”, “Аймаг, дүүргийн түвшинд хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулна”, 2.2.10-т “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх” арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.5-д “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль”-ийн төслийг батлуулахаар, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтын 151-д “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай” хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барихаар тусгасан.

## **1.2. Практик хэрэгцээ, шаардлага**

Эрүүл мэндийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэсэн хоёр төрөлтэй болохыг тодорхойлж, хүн амын эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжүүлэхэд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ тэргүүлэх чиглэл болгох үндсэн зарчим баримтлахыг заасан боловч нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чиглэл болгон хөгжүүлээгүй байна.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үндэсний тогтолцоо, түүний зохицуулалт, төрөл, бүтэц, чиг үүрэг тодорхойлогдоогүй бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2012 оны 250 дугаар, 2014 оны 415 дугаар, 2020 оны А/38 дугаар тушаалаар тус тус “Нийгмийн эрүүл мэндийн төв” байгуулах шийдвэр гарч байсан бөгөөд аймаг, дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн салбар, нэгж зохих ёсоор үйл ажиллагаа явуулаагүй. Түүнчлэн дээрх шийдвэрүүд хэрэгжээгүй нь хэм хэмжээний актаар нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтцийг зохион байгуулах, зохицуулах боломжгүйг харуулж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тодорхойлсон нийгмийн эрүүл мэндийн нэн шаардлагатай 10 тусламж, үйлчилгээг үзүүлж чадахгүй байгаа бөгөөд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үйл ажиллагаа бүхэлдээ орхигдсон байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас нийгмийн эрүүл мэндийн нэн шаардлагатай дараах 10 тусламж, үйлчилгээг тодорхойлсон. Үүнд:

1. Хүн амын эрүүл мэндийн байдлыг судлах, тандах;
2. Эрүүл мэндийн аюул, эрсдэл, онцгой байдлын үед шуурхай арга хэмжээ, авах тогтмол, хянах, орчны болон хүнсний аюулгүй байдлыг хангах;
3. Эрүүл мэндийг хамгаалах бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
4. Эрүүл мэндийг дэмжих, нийгмийн сөрөг хүчин зүйлийн нөлөө, тэгш бус байдлыг багасгах;
5. Өвчин эмгэгээс урьдчилсан сэргийлэх, эрт оношилж илрүүлэх;
6. Эрүүл мэндийн үйчилгээг оновчтой удирдан, зохион байгуулах;
7. Нийгмийн эрүүл мэндийн чадварлаг боловсон хүчний нөөцийг хүртээмжийг бүрдүүлэх;
8. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үзүүлэх бүтэц, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах;
9. Хүн амыг бодитой мэдээллээр хангаж эрүүл мэндээ хамгаалахад татан оролцуулах, идэвхжүүлэх;
10. Нотолгоо түшсэн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үүдээс нийгмийн эрүүл мэндийн судалгааг хөгжүүлэх.

Монгол Улсын хөдөлмөрийн насны хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааны 77 хувийг халдварт бус өвчин буюу сэргийлж болох өвчлөл, нас баралт эзэлж байна.<sup>1</sup> Монгол хүний дундаж наслалт 2020 оны байдлаар 70.7, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 76.2, эрэгтэйчүүдийнх 66.7 буюу 9.5 жилээр зөрүүтэй, Монгол Улс дэлхийд хорт хавдрын, ялангуяа элэгний хорт хавдрын өвчлөл, нас баралтаар тэргүүлж байна. Монгол Улсад цаашид биотехнологи, инновацид суурилсан урьдчилан сэргийлэх, дархлаа сэргээх биобэлдмэл, вакцин, оношлуур бүтээх, үйлдвэрлэх, хангах нийлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Хотжилт, үйлдвэржилт, хэт төвлөрөл нь ахуйн, хүнсний аюулгүй байдал, химийн бодисын хэрэглээ, өртөлт, хордлого нэмэгдэх, агаар, орчны бохирдол, хүний амьдралын буруу хэв маягаас шалтгаалсан өвчлөлд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн зохицуулалт хангалтгүйгээс хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа амьсгалын, зүрх судасны тогтолцоо, хоол боловсруулах замын, хортой, хоргүй

---

<sup>1</sup> Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын шаталсан IV судалгаа



хавдрын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулж байгаа 1 ам.доллар нь ирээдүйд эмнэлгийн тусламж, үйлчилгээнд зарцуулах 40 хүртэлх ам.долларыг хэмнэнэ, эрүүл мэндийн салбарын нийт зардлын 30-аас доошгүй хувийг нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулахыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага зөвлөдөг. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, ангилал, стандарт, норматив, жишиг тооцоолол байхгүйгээс нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, нэр төрөлд өртөг зардлын тооцоо тодорхойгүй байгаа нь хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна.

Хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үндэсний тогтолцоо бүрэн бүрэлдээгүй, тусламж, үйлчилгээний төрөл, зохион байгуулалт, санхүүжилттэй холбоотой зохицуулалт тодорхойгүй байна. Эрүүл мэндийн тухай хуульд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн төрөлтэй байхаар зааж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо, төрөл, зохион байгуулалт болон санхүүжилтийг 2016 оноос хойш Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар зохицуулж байна. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх тогтолцоо, төрөл, зохион байгуулалт болон санхүүжилтийн асуудлыг орхигдуулсныг энэ хуулиар зохицуулахаар төсөлд тусгана.

Хүн амын бүлэгт чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ дутагдалтай байна. 2022 онд зохион байгуулсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, оношилгоо, шинжилгээнд Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр нийт 781,765 хүн хамрагдсан.<sup>2</sup> Хүүхэд бүрийг 9, 18, 36 сартайд нь эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамруулан аливаа өвчин эмгэг, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, 65-аас дээш насны ахмадуудыг “Настны цогц үзлэг”-т хамруулах ажил бүрэн хийгдэхгүй байна. 2022 онд 45,705 иргэн цэрэг татлагаар эрүүл мэндийн үзлэгт хамрагдсанаас 15,082 иргэн буюу 3 хүн тутмын 1 нь эрүүл мэндээр цэргийн албанд тэнцээгүй байна. Ийм учраас Монгол Улсын иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах эрх, үүргийг хуулийн төсөлд тусгана.

Эрүүл мэндийн салбарын 50 мянга гаруй ажиллагсдын дөнгөж 1.9 хувь нь нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн байгаа нь эмнэлгийн тусламж, үйлчилгээг хэт шүтсэн, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орхигдуулсныг харуулж байна. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, стандарт, норматив, жишиг тооцоолол байхгүйгээс тусламж, үйлчилгээний багц, өртөг зардлын тооцоо тодорхойгүй байна.

---

<sup>2</sup> Эрүүл мэндийн хөгжлийн төв (2022 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн мэдээ)

Дэлхий дахинд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлыг үүсгэж байгаа зоонозын гаралтай халдварууд сүүлийн жилүүдэд ихсэж, жил бүр 2.7 сая орчим хүн нас барж<sup>3</sup> байгаа нь шинэ болон сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, тандах, судлах, эрсдэлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах үйл ажиллагааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2005 онд баталсан “Олон улсын эрүүл мэндийн дүрэм”-д нийгэм, эрүүл мэндийн ноцтой байдлыг үед тухайн улс орны нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг тухайн асуудал хариуцсан төрийн байгууллага бүхэлд нь удирдан чиглүүлж, шийдвэрлэхээр заасантай нийцүүлнэ. Энэ дүрэмд дэлхийн 194 улс орон нэгдэн орсон бөгөөд Монгол Улс үйл ажиллагаагаа үүнд нийцүүлэхээр тусгана.

Монгол Улсын хувьд дээрх тодорхойлсон нийгмийн эрүүл мэндийн нэн шаардлагатай 10 тусламж, үйлчилгээг холбогдох бүтэц, зохион байгуулалтын дагуу улс орон даяар жигд, хүртээмжтэй хүргэж чадахгүй байгаа бөгөөд энэхүү нөхцөл байдал нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зайлшгүй хуульчлах шаардлага үүсээд байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн үндэслэл болон практи хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулна.

### **Хоёр.Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц**

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан анхдагч хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн зорилт нь хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн төсөлд дараах асуудлыг зохицуулахаар тусгана:

1.Хуулийн зорилт, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуульд хэрэглэгдэх нэр томъёоны тодорхойлолт, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үйл ажиллагаанд баримтлах зарчим зэргийг тусгана.

2.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, зохион байгуулалт, тогтолцоонд нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан үндэсний хэмжээний

<sup>3</sup> <https://pastoralismjournal.springeropen.com/articles/10.1186/s13570-017-0109-x>

байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн чиг үүргийг тодорхойлж тусгана.

3.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний удирдлагын тогтолцоо төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг тодорхойлж, бүх шатны Засаг даргын эрх, үүргийг тодорхойлж тусгана.

4.Иргэний эрх, үүрэг, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг тодорхойлж, олон нийтийн болон хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог бүрдэх зохицуулалтыг тусгана.

5.Нийгмийн эрүүл мэндийн ажилтны эрх, үүргийг нарийвчлан тодорхойлж, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын нэгэн адил нийгмийн баталгаа, нэмэгдэл хөлс, нөхөн төлбөр олгохоор тусгана.

6.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, Засгийн газрын тусгай сан, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олны хандив, эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээ, бусад үйл ажиллагааны орлого болон хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэх зохицуулалтыг тусгана.

7.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хангахтай холбогдуулан хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зохицуулалтыг тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвийн санхүүжилт шаардагдахгүй ба тухай ондоо батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах бөгөөд эрх зүйн орчныг бүрдүүлснээр урт хугацаанд нийгэм, эдийн засагт дараах эерэг үр дүн гарна гэж үзэж байна. Үүнд:

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цар хүрээ, хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, бусад салбарын оролцоо тодорхой болж, Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ эрүүл мэндийн салбарын тэргүүлэх чиглэл болон хөгжинө.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үндэсний тогтолцоо бий болсноор Монгол Улсын хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан

болох халдварт, халдварт бус өвчлөл бодитоор буурч, цаашид гарах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх хууль зүйн зохицуулалттай болно.

Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сантай болж, нотолгоонд суурилсан шийдвэр гарах нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт тодорхой болж, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд зарцуулах зардлыг бууруулснаар эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн оновчтой хуваарилалт тодорхой болно.

Иргэн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндээ хамгаалах насан туршийн боловсрол олгосноор өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэхэд бүх нийтийг хамруулах зорилт биелэх боломжтой болно.

**Дөрөв.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад шаардлагатай хуулийн төслүүдийг тус тус боловсруулна.

--- оОо ---